

**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН АРТБАЗАРЫН БАЯРЗАЯАГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

96*

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
ЗГҮАХХАХТ 2.3.2.1.23, 25.72							
Арга хэмжээ 1.1. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийн зохицуулалтыг хангана.							
1.	Дэд арга хэмжээ – 1.1.1 Холбогдох аймаг, орон нутгийн төвлөрлийг сааруулах тусламж, үйлчилгээний хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа гаргана.	Төлөвлөгөө боловсруулс ан байна	Орон нутгийн хүн амын өвчлөл, нас баралт, тусламж, үйлчилгээний хүртээмж, төвлөрлийн судалгаа	Орон нутгийн өвчлөл, нас баралт, хүртээмж, хүчин- чадалд суурилан шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг гаргах	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын 2024 оны эрүүл мэндийн даатгалын санхүүжилт авсан байдлыг харахад харьяалах хүн амынхаа 50%- ийг төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон бусад эмнэлэг рүү хавдар, харвалт, шигдээс, осол гэмтлийн оношоор амбулаторийн үзлэг, шинжилгээ, оношилгоо, өндөр өртөгт тусламж, үйлчилгээнд илгээсэн байна. 2021 онд ангиографийн аппарат, тоног төхөөрөмж суурилагдсан 5 аймгийн БОЭТ, нэгдсэн эмнэлгийн хавдар, хими эмчилгээ, зүрх, мэдрэл, хэвлийн ангиографийн оношилгоо, эмчилгээ, зүрхний хэм алдагдал,	03-06	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Өуурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					гэмтлийн мэс заслын 63 хүнинэн тэргүүнд мэргэшүүлэх шаардлагатай байхад, 26 нэр төрлийн 150 ширхэг тоног төхөөрөмж шаардлагатай байна .		
2.	Дэд арга хэмжээ–1.1.2: Төвлөрлийг сааруулах хүрээнд хүний нөөцийг чадавхжуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, ханган нийлүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	ЭМС-ын тушаал	Мэргэшсэн хүний нөөц, хангагдсан тоног төхөөрөмжийн тоо, хувь	Сайдын тушаал боловсруулж батлуулсан байна.	Төвлөрлийг сааруулах төлөвлөгөөний үндэслэлийн судалгааг гаргасан, төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	01-06	
“Алсын хараа-2050” 2.2.11., ЗГ-ын 78 дугаар тогтоолын 5.4.4, 25.73 Арга хэмжээ 2.1. Орон нутагт нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах үндэсний багийн үйл ажиллуулна (хавдар, эх барих, ангиография, гэмтэл согогийн мэс засал).							
1.	Дэд арга хэмжээ–2.1.1: Орон нутагт ажиллах үндэсний багийн хуваарь гаргаж, батлуулна.	ЭМ-ийн сайдын тушаал	Орон нутагт үйл ажиллагаа яввуулсан үндэсний багийн тоо	Үндэсний багийн үйл ажиллагааны тогтолцоо бүрдсэн байна	1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Төвлөрлийг сааруулах үндэсний багийн ажиллах журам батлах тухай” А/113 дугаар тушаалаар хавдрын мэс засал, хавдрын хими, бай эмчилгээ, зүрх, судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ, мэдрэлийн ангиографийн оношилгоо, эмчилгээ, гэмтлийн мэс	01-06	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
					засал, зүрхний хэм алдагдал, хоол боловсруулах замын дурангийн оношилгоо, эмчилгээ, яаралтай тусламж, эх барих, эмэгтэйчүүд, хүүхэд нярайн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагаас тухайн тусламж, үйлчилгээг аймаг, дүүрэгт нутагшуулах мэргэшсэн эмч нарын орон нутагт ажиллахтай холбоотой харилцааг зохицуулсан. 2. 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилго бүхий "Хүүхэд нярай"-н үндэсний баг, "Хүүхэд нярай, үргийн мдийн—мэс засал"-ын үндэсний багийг томилсон. 3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 12-т төвлөрлийг сааруулах тусламж үйлчилгээ, үндэсний багийг санхүүжүүлэх тухай тусгасан.		
2.	Дэд арга хэмжээ – 2.1.2: Үндэсний багийн	Орон нутагт үйл	Орон нутагт үйл ажиллагаа	Үндэсний багийн үйл	2024 оны 8 дугаар сараас Үндэсний багуудыг томилон 1 аймагт 3-4 сард 1	01-06	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
	үйл ажиллагааны хэрэгжилтийг хангана	ажиллагаа явуулсан үндэсний багийн тоо	яввуулсан үндэсний багийн тоо	ажиллагааны тогтолцоо бүрдсэн байна	удаа ажиллуулахаар хуваарь гаргаж нийт 136 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 3-8 хүний бүрэлдэхүүнтэй 5-10 хоног ажиллуулахад нийт 6963 хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд нийт хавдрын амбулаторийн үзлэг-1909 хүнд, хавдрын ЭХО-оношилгоо 184 хүнд, хавдрын ангиографийн оношилгоо 121 хүнд, хавдрын ангиографийн эмчилгээ 68 хүнд, хавдрын мэс засал 44 хүнд, хими эмчилгээний үзлэг 645 хүнд хийснээс 123 хүнд хими, бай эмчилгээ хийсэн байна. Үндэсний багууд зүрхний шигдээс болон бусад архаг эмгэгтэй 1648 хүнд үзлэг хийснээс ангиографийн оношилгоо—228—хүнд,—ангиографийн эмчилгээг 143 хүнд хийсэн байна. Үндэсний багийн мэдрэлийн ангиографийн эмч нар 627 мэдрэлийн судасны эмгэгтэй хүнд үзлэг хийснээс ангиографийн оношилгоонд 111 хүн, ангиографийн эмчилгээнд 15 хүн орсон байна. Зүрхний хэм алдагдлын оноштой болон сэжигтэй 467 хүнд үзлэг хийснээс 58 хүнд холтер оношилгоо, 22 хүнд тур зуурын пейсмэйкер тавих зэрэг ажилбар хийсэн. Гэмтлийн үндэсний багийн эмч нар Ховд, Говь-Алтай аймагт ажиллаж		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					52 хүнд үзлэг хийж 24 хүнд өвдөг, түнхний үе солих болон бусад төрлийн мэс засал хийсэн байна. Мөн хүүхэд, эмэгтэйчүүд, сэхээн амьдруулах болон яаралтай тусламжийн тусламж үйлчилгээг Баянхонгор, Завхан, Дархан-Уул аймаг үзүүлж нийт 195 хүнд үзлэг, оношилгоо, эмчилгээ хийсэн.		

МУТЖҮЧ 2.2.6, 25.98

Арга хэмжээ 3.1. Зайн оношилгооны төвийн (дүрс оношилгооны) үйл ажиллагааны журмыг батлуулж, хэрэгжүүлнэ.

1.	Дэд арга хэмжээ – 3.1.1. Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны журмыг боловсруулна.	Гүйцэтгэлд эзлэх хувь			Зайн оношилгооны төвийн үйл ажиллагааны журмыг боловсруулсан, 5 дугаар сарын 10-ны өдрөөс ЭМЯ-ны газар хэлтсээс санал авч байна.	01-06	
2.	Дэд арга хэмжээ – 3.1.2. Зайн оношилгооны төвийн журмын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулна.	Гүйцэтгэлд эзлэх хувь			Улсын хоёрдугаар төв эмнэлэгт дүрс оношилгооны “Зайн оношилгооны төв” байгуулж аймаг, орон нутгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дүрс оношилгооны хариуг зайнаас бичих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн үйл ажиллагаа бүхий алба байгуулсан. “Зайн оношилгооны төв”-д 6 хүний орон тоо бүхий эмч, мэргэжилтнүүд Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх	01-06	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
					хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлгээс ажиллаж байна. Тус төвийн үйл ажиллагааг 2024 оны 12 сард үйл ажиллагаа эхлүүлснээс хойш тайлант хугацаанд 18 аймгийн 2217 хүний рентген зураг, Компьютер томографи шинжилгээний хариунд дүгнэлт бичиж, эмч мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч ажилласан байна.		
Арга хэмжээ 4.1. Түгээмэл үйлдлийн стандартын ерөнхий сувилахуйн үйлдлүүдийн стандартыг батлуулна.							
1.	Арга хэмжээ 4.1.1. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас авсан саналыг тусгах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь			Түгээмэл үйлдлийн стандартын ерөнхий сувилахуйн үйлдлүүдийн стандартыг Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хорооны 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Техникийн хорооны гишүүдийн саналыг тусгаж, дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан. Техникийн хорооны 5 гишүүний 11 саналыг бичгээр авч баталгаажуулан тусгасан. Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний	01-06	

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
					стандартчиллын техникийн хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлнэ.		
Арга хэмжээ 5.1. Аймаг, орон нутагт лабораторийн чанарын гадаад хяналт, үнэлгээний үйл ажиллагааны хэрэгжилтийг хангана.							
	Дэд арга хэмжээ – 5.1.1. Аймаг орон нутгийн лабораторийн чанарын гадаад хяналтыг зохион байгуулах аймгуудын эмч нарт зориулсан сургалт зохион байгуулах.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь			Эрүүл мэндийн лабораторийн мэргэжилтний Гуравдугаар хурал, Лабораторийн 7 хоног арга хэмжээний хүрээнд “Лабораторийн гадаад–үнэлгээг–орон–нутагт–сум, өрхийн Эрүүл мэндийн төвд хэрхэн зохион байгуулах тухай” сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Сургалт хэлэлцүүлэгт нийт 21 аймгийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, аймгийн БОЭТ, Нэгдсэн эмнэлгийн лабораторийн эрхлэгч, эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, лаборант нар болох 61 хүн оролцов. Сургалтыг ЭМЯ, Лабораторийн мэргэжлийн	01-06	
2.							

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					салбар зөвлөл, ХӨСҮТ, УНТЭ, Интермед эмнэлэг хамтран зохион байгуулсан.		

Хоёр. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

	Өрх, сумын эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн стандартын төслийг боловсруулсан байна	Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн MNS 5081:2013, Өрхийн эрүүл мэндийн төвийн MNS 5292:2017 стандартыг шинэчлэх	Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг	Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг ЭМС-ын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/512 дугаар тушаалаар баталж, 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/143 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Ажлын-хэсгийн-бүрэлдэхүүн-2025-оны-2-5 сард нийт 4 удаа хурал хийж одоогийн хэрэгжиж байгаа анхан шатны тусламж, үйлчилгээний бодлогын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн MNS 5081:2013, өрхийн эрүүл мэндийн төвийн MNS 5292:2017 стандартын шаардлагын бусад хяналт, үнэлгээний шалгууртай (Эрүүл мэндийн сайдын А/383, А/122, А/321, А/321, магадлан итгэмжлэлийн болон) нийцлийг үнэлэх, Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын төсөл		
1.				төслийг шинэчлэн боловсруулж санал авахад бэлэн болгосон байна.			

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					боловсруулах,, 2-3 өрх, сумын эрүүл мэндийн төвд туршиж үнэлэх, төсөлд холбогдох эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоодын саналыг авч тусгах, төсөлд холбогдох байгууллага, нийгэмлэг, холбоодыг хамтарсан цахим хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээг тусгаж төлөвлөгөө боловсруулсан. Мөн ДЭМБ-д тус ажлын хэсгийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талаар удирдамж, хүсэлт хүргүүлсэн. Тайлант хугацаанд сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн стандартын төслийг ажлын хэсгийн үнэлгээний-ажил-хийгдэж байна, мөн 2 стандартын төсөл боловсруулж байна.		
2.	МУХТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-2.3.2.6 МУХТ 3.1.2.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ыг хөгжүүлнэ	Телемедицины журмыг боловсруулж санал авахад бэлэн болгосон байна.	ЭМС-ын 2013 оны 09 сарын 11-ны өдрийн 330 дугаар тушаалаар “Телемедицинний үйлчилгээний ажиллах журам”-ыг шинэчлэх	Журмын төслийг боловсруулж санал авахад бэлэн болгосон байна.	Алсын зайн үйлчилгээг зохицуулах ЭМС-ын 2013 оны 09 сарын 11-ны өдрийн 330 дугаар тушаалаар “Телемедицинний үйлчилгээний ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж ЭМЯ-ны газар хэлтсээс санал авахаар 5 дугаар сарын 10-ны өдрөөс тойруулж байна. Энэхүү журам шинэчлэгдсэнээр эрүүл мэндийн байгууллагуудын шатлал		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
					хоорондын ачаалал багасна, иргэн тухайн оршин суугаа орон нутгаасаа санхүүгийн эрсдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломж бүрдэнэ, алсын зайн оношилгоог хөгжүүлснээр хөдөө болон алслагдсан аймаг орон нутагт дүрс оношилгооны эмч мэргэжилтнүүдийн дутагдлаас үүдэлтэй оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, түргэн шуурхай үзүүлэх боломж бүрдэнэ, нарийн мэргэжлийн мэргэшсэн эмчээс цаг алдалгүй зайнаас зөвлөгөө авах боломж бүрдэнэ.		
3.	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулах	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох талаар бодлогын баримт бичгийг		Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох хуулийн төсөлд Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур, үйл ажиллагааг зохицуулах тухай саналыг	Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16,17 дугаар хэсэгт заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зөвшөөрөл олгох холбогдох журмыг нягтлан Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй журмыг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зохицуулгатай холбоотой тушаалыг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 2		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
		боловсруулах		боловсруулж хүргүүлэх	дугаар сарын 10-ны өдрийн А/40 дугаар тушаалаар хүчингүй болгосон. Үүнтэй холбогдуулан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль, журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах болон журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг ЭМС-ын 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалаар батлагдсан. Тус ажлын хэсэг нийт 6 удаа хурал, хэлэлцүүлэг хийж ЗГХЭГ-т 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 1а/1074 дугаар, 4 дүгээр сарын 11-ний өдрийн 1а/1802 дугаар, 6 дугаар сарын 10-ны өдрийн 1а/3053 дугаар албан бичгээр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд саналыг хүргүүлсэн.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
		Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
	1	2	3	4	5	6	7
4.	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах	Тусгай зөвшөөрлийн комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Тусгай зөвшөөрлийн асуудлаар ирүүлсэн хүсэлт, санал		Тусгай зөвшөөрлийн комиссын 2025 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн шийдвэрийг хангах хүрээнд ЭМС-ын 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А/46 тушаалыг батлуулж 2 эмнэлэгт тусгай зөвшөөрөл олгож, 1 эмнэлгийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 1 эмнэлгийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн ЭМС-ын 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/50 тушаалыг батлуулж 2 эмнэлэгт тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.		
5.	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн хурлын шийдвэрийг ЭМС-ын тушаалаар батлуулах	Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 12 удаагийн хурлыг зохион байгуулж 157 эрүүл мэндийн байгууллагын асуудлыг хэлэлцэж, 131 байгууллагад магадлан итгэмжлэл олгох тухай ЭМС-ын 11 тушаал батлуулсан.		

1. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Албан тушаалын онцлогоос хамааран гадаад хэл, мэдээллийн технологийн болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж эсхүл бие даан суралцах эзэмших	Сургалтад хамрагдсан багц цагийн гэрчилгээ			"ISO 15189 стандартын 4-р хэвлэлийн гол өөрчлөлтүүд, Япон дахь эмнэл зүйн лабораторийн итгэмжлэлийн өнөөгийн байдал" сургалтад хамрагдсан	2025.04.24	2025.04.27

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНХАН, ЛАВЛАГАА
ШАТЛАЛЫН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН
ОРОН НУТГИЙН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

А.БАЯРЗАЯА /

2025.06.10

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНХАН, ЛАВЛАГАА
ШАТЛАЛЫН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

С.ЖАРГАЛСАЙХАН /

2025.06.10